

БНМАУ, БНАГУ -ЫН ХООРОНД 1971-1975 ОНЫ  
УЛС АРДЫН АЖ АХУЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ЗОХИ-  
ЦУУЛАЛТЫН АСУУДЛААР ХИЙСЭН ХЭЛЭЛЦЭЭРИЙН  
П Р О Т О К О Л

Эдийн Засгийн Харилцан Тусламцах Зөвлөлийн ХХШ тусгай болон ХХІҮ чуулганы тогтоолын дагуу БНМАУ, БНАГУ-ын засгийн газрын төлөөлөгчдийн хооронд тус хоёр орны 1971-1975 оны улс ардын аж ахуйн төлөвлөгөө зохицуулалтын асуудлаар Улаанбаатар хотноо 1970 оны 12-р сарын 3-наас 7-ныг дуустал Хэлэлцээр хийв.

Хэлэлцээрийг Монголын талаас-БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга, Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах засгийн газар хоорондын Комиссын БНМАУ-ын хэсгийн дарга н.Д.Гомбожав, Германы талаас-БНАГУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга, Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах засгийн газар хоорондын Комиссын БНАГУ-ын хэсгийн дарга н.доктор В.Титель нар тэргүүлэв.

Хэлэлцээрт БНМАУ-ын Улсын Төлөвлөгөөний Комиссын дарга н.Б.Ринчинпилжээ оролцлоо. Хэлэлцээрт оролцогсодын нэрсийг хавсаргав. / I-р хавсралт/

I

Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга нар, тус хоёр орны нам засгийн төлөөлөгчдийн 1968 оны 9-р сард тохиролцосныг үндэс болгон хоёр орны эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх, мөн түүнчлэн хоёр орны нам, засгийн удирдагчдийн хоорондын захидлыг үндэс болгон 1971-1975 онд БНМАУ, БНАГУ-ын хоорондын эдийн засгийн харьцааг хөгжүүлэх асуудлаар саналаа солилцов.

1968 оны 9-р сарын 12-нд байгуулсан найрамдал, хамтын ажиллагааны Гэрээний үндсэн дээр, пролетарийн интернационализмын үзэл санаа, хоёр орны сонирхолд тохируулан БНМАУ-д аж үйлдвэрийн газрууд барьж байгуулах, хөдөө аж ахуйн арга

хэмжээ, геологийн зураглал, эрэл, хайгуулын ажлыг оролцуулан БНМАУ, БНАГУ-ын хооронд эдүүгээ хүртэл явуулсан эдийн засгийн хамтын ажиллагаа зүгээр үр дүнд хүрлээ гэж хоёр Тал үзэж байна.

Хэлэлцээрээр:

- Улаанбаатар хотын махкомбинат, хивсний үйлдвэрийг Монголын ардын хувьсгалын 50 жилийн ойн наана барьж дуусгах, тэдний хүчин чадлыг үр ашигтай ашиглах талаар хамтарсан арга хэмжээ авах;
- Хамтран хайгуул хийсэн алтны орд газрыг үйлдвэрийн чанартай ашиглах, Бүрэнцогтын вольфрамын уурхай болон баяжуулах фабрикийг өргөтгөх;
- Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах;
- БНМАУ-д БНАГУ-аас эдүүгээ хүртэл олгосон зээлийг төлөх;
- Хоёр орны хоорондох барааны эргэлтийг 1971-1975 онд цаашид нэмэгдүүлэх тухай асуудлыг ярилцав.

Хэлэлцээрийн дүнд хоёр Тал дараах зүйлийг ярьж тохирлоо.

## II

а/ Улаанбаатарын махкомбинатын 2-р ээлж, хивсний үйлдвэрийг Монголын ардын хувьсгалын 50 жилийн ойн өмнө ашиглалтанд оруулах зорилгоор барьж дуусгах бүх арга хэмжээг хамтарсан хүчээр авч явуулна.

Махкомбинат, хивсний үйлдвэрийн барилгыг дуусгахад шаардагдах хөрөнгө-3,3 сая орчим рублийг 1965, 1969 онд байгуулсан хэлэлцээрээр БНАГУ-аас БНМАУ-д олгосон зээлээс гаргахаар хоёр Тал тохиролцов.

Махкомбинат, хивсний үйлдвэрийг барихад БНАГУ-ын талаас үзүүлсэн дэмжлэгтэй холбогдуулан БНМАУ 1971-1975 онд БНАГУ-д 17 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 400 мянган хавтгай дөрвөлжин метр хивс тус тус нийлүүлнэ.

Махкомбинат, хивсний үйлдвэрийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг зохистой ашиглах, эдийн засгийн өндөр үр ашигтай байлгах сонирхолын үүднээс БНМАУ-ын хүсэлтийн дагуу БНАГУ эдгээр

Үйлдвэрүүдийн орчин үеийн социалист эдийн засгийг хөгжүүлэхэд шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны хүрээнд дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлэв. Үүнээс гадна эдгээр үйлдвэрүүдийн тасралтгүй ажиллагааг хангахын тулд БНАГУ 1971-1975 онд зайлшгүй шаардагдах сэлбэг хэрэгсэл, солих тоног төхөөрөмж, материалыг худалдаагаар нийлүүлнэ.

Дээр дурьдсан асуудлуудтай холбогдсон саналыг хоёр Талын эрх бүхий байгууллагуудын бүрэн эрхт төлөөлөгчид БНМАУ, БНАГУ-ын Засгийн газар хоорондын комиссын III хуралдаанд бэлтгэн оруулна.

Хоёр Тал цаашдын хамтын ажиллагаанд БНАГУ-ын техник эдийн засгийн тусламжтайгаар БНМАУ-д барьж байгаа аж үйлдвэрийн газруудын хүчин чадлыг бүрэн эзэмших, тэдгээрийн эдийн засгийн үр ашгийг төсөлд заасан хэмжээнд хүргэх, үйлдвэрүүдийн хэвийн ажиллагааг хангахад онцгой анхаарал тавих нь чухал гэж үзэв.

6/ Хоёр Тал Бүрэнцогтын вольфрамын уурхайд үйлдвэрлэл-техникийн болон өргөтгөлийн арга хэмжээг аль болох богино хугацаанд харилцан ашигтайгаар явуулах сонирхолтой байна.

Бэлтгэл ажил хийгдэсний дараа үйлдвэрлэл-техникийн ба өргөтгөлийн арга хэмжээг 2 жилийн дотор хийхээр хоёр Тал тохирлоо.

Иймд хоёр Тал дээр дурьдсан арга хэмжээ, түүний бэлтгэл ажлыг явуулах хугацааг богиносгохыг эрмэлзэх болно.

Уурхайн үйлдвэрлэлийн хүчин чадлыг жилд 60 хувь вольфрам бүхий 500 тн концентрат гаргахад хүргэхээр хоёр Тал тохиролцлоо.

Хоёр Тал өргөтгөлийн дараа үйлдвэрийн үйл ажиллагааг үр ашигтай байлгах сонирхолтой байна.

Хоёр Тал өргөтгөлийн дараа 60 хувийн концентратыг үйлдвэрлэхэд өөрийн өртгийг хямдруулахыг сонирхоно.

Эргэтгэлийн ажлыг тохиролцсон хэмжээгээр явуулахад Германы талаас олгох зээлийн хэмжээ 1,0 сая рублээс хэтрэхгүй байвал зохимжтой гэж хоёр Тал үзэж байна.

БНАГУ-ын Засгийн газраас олгох зээлийг Бүрэнцогтын уурхайн одоогийн тогтоогдсон хүчин чадал буюу 275 тонноос давуулан жил бүр гаргах 60 хувийн вольфрам бүхий концентратын тодорхой хэсгээр төлж байхаар хоёр Тал тохиролцлоо.

БНАГУ-д ажиллаж байгаа БНАГУ-ын геологийн экспедици нь БНАГУ ба БНАГУ-ын Засгийн газар хоорондын Комиссын I, II хуралдааны шийдвэрийг биелүүлэн 1970 онд Бороогийн алтны орд газруудад геологи хайгуулын ажлыг амжилттай явуулж дууссаныг хоёр Тал сэтгэл хангамжтай тэмдэглэж байна.

Бороогийн алтны орд газруудыг хамтран ашиглах бэлтгэл ажилд эхлэж орохоор хоёр Тал тохиролцов.

БНАГУ-ын Засгийн газар Бороогийн районд алт олзворлох үйлдвэрийн газар байгуулахад зориулан 7 сая рублийн зээл олгоход бэлэн байна.

Алт олзворлох үйлдвэр байгуулах боломжийн тухай урьд боловсруулсан материалуудаа хамтран бүх талаас нь судлаж техник эдийн засгийн бүрэн тохиролцсон үзүүлэлтүүдийг 1971 оны III улиралд дээд байгууллагууддаа гарган өгч үүнийхээ үндсэн дээр Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах ажилд орохыг өөрсдийнхөө эрх бүхий холбогдох байгууллагууддаа даалгахаар хоёр Тал тохиролцов.

Монголын тал нь БНАГУ-ын мэргэжилтэн нарын оролцоотойгоор Бороогийн орд газруудын нөөцийг үндэслэн алт олзворлох үйлдвэрийн газар байгуулах төслийн даалгаварыг боловсруулж БНАГУ-ын хүч хөрөнгөөр төсөл зохиолгохын тул 1971 оны I сард БНАГУ-ын талд шилжүүлэхээр хоёр Тал тохиролцов.

1971 оны I-р сарын I-нээс эхлэн Нарантолгойн орд газрын уулын малталтыг зохих ёсоор тордох ажлыг Монголын тал хариуцна.

Хэрэв шаардлагатай болбол хамгийн бага зардал гарган БНАГУ-ын мэргэжилтнийг ирүүлж монгол ажилчдыг зарим төрлийн ажилд дагалдуулан сургах тухай асуудлыг боловсруулах нь зүйтэй гэж хоёр Тал үзлээ.

Үүнд хоёр тал ойрын өдрүүдэд уг асуудлын талаар зохих контракт байгуулана.

Ирээдүйн үйлдвэрийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэхийн тулд 1971 онд БНМАУ-ын холбогдох эрх бүхий байгууллагын захиалгын дагуу БНАГУ-ын мэргэжилтэн нар Монгол мэргэжилтнүүдийн оролцоотойгоор Бороогийн орд газруудын гидрогеологийн шинжилгээний ажлыг явуулах нь зүйтэй гэж хоёр Тал үзэж байна.

Ирээдүйн үйлдвэр байгуулах районд гидрогеологийн шинжилгээ явуулах, мөн түүнчлэн Нарантолгойн орд газрын уулын гүний малталтуудыг тордох ажилтай холбогдсон зардлыг Засгийн газар хоорондын 1965 оны Хэлэлцээрийг үндэслэн БНАГУ-ын Засгийн газраас олгосон зээлийн үлдэгдлээс санхүүжүүлэнэ.

БНАГУ-ын тал 1971-1975 онуудад шинэ объектийн геологи-хайгуулын ажил явуулах талаар БНМАУ-ын саналыг судалж үзэхэд бэлэн байгаагаа илэрхийлэв.

Хүч хөрөнгө хамтран гаргаж геологи-хайгуулын ажил явуулах хамтын ажиллагааны хэлбэрийн талаар БНМАУ-ын тал санал тавьлаа.

Монголын талын тодорхой саналыг дээр дурьдсан салбарт хоёр орны хамтран ажиллах хэлбэрийн тухай Засгийн газар хоорондын комиссын II хуралдааны тогтоолын дагуу БНАГУ-ын тал судалж засгийн газар хоорондын Комиссын III хуралдаанд энэ асуудлаар саналаа өгөхөд бэлэн байгаагаа илэрхийлэв.

Хоёр тал тэнцүү хөрөнгө гаргаж 1971 онд Нарантолгойн орд газрын орчим 1:50000 масштабын геологийн зураглалын ажил явуулах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг



1971 оны III сард байгуулахаар хоёр Тал тохиролцов.

в/ 1966 оны 3-р сарын 19-ний хэлэлцээрээр БНАГУ-ын талаас урьд олгосон зээлийн үлдэгдэл 100 мянга орчим рублийг 1971 онд хөдөө аж ахуйн лабораторийн тоног төхөөрөмж авахад ашиглахаар хоёр Тал тохиролцов.

БНАГУ-ын засгийн газар БНМАУ, БНАГУ-ын засгийн газрын хоорондын Комиссын <sup>1969-1970 он</sup> тогтоолын үндсэн дээр эхэлсэн хөдөө аж ахуйн салбарын арга хэмжээг цаашид зээл олгох замаар үргэлжлүүлэхэд бэлэн байгаагаа Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын төлөөлөгчид мэдэгдэв.

Монголын төлөөлөгч БНАГУ-ын төлөөлөгчид талархалаа илэрхийлж хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах асуудлын талаар ойрын хугацаанд саналаа өгнө гэж мэдээлэв.

### III

Эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, ялангуяа БНМАУ-ын үр ашигтай экспортын бололцоог нэмэгдүүлэх үйлдвэрийг барьж байгуулах талаар тохиролцосныг үндэслэж 1971-1975 онд харилцан солилцох бараа нилээд өсөх болов.

БНМАУ-д БНАГУ машин сэлбэг хэрэгсэл, химийн бүтээгдэхүүн, өргөн хэрэгцээний бараа нийлүүлэх бөгөөд БНАГУ-д БНМАУ мах, махан бүтээгдэхүүн, хивс мал аж ахуйн янз бүрийн бүтээгдэхүүн, савхин эдлэл, уулын үйлдвэрийн бүтээгдэхүүн экспортлох болно.

Удаан хугацаанд харилцан нийлүүлэхээр тохиролцсон зүйлийг 2,3-р хавсралтанд заав.

2,3-р хавсралтанд заасан барааг харилцан бараа нийлүүлэх удаан хугацааны хэлэлцээр хийхэд жил, жилээр нь хувиарлах болно. Хувиарлалтыг хийхдээ жил, жилд тэгш байх боломжийг бодолцоно.

Хоёр Тал, импортын хэмжээг бүрэн тохиролцоогүй тул цаашдаа энэ асуудлыг жил, жилийн протокол хийх хэлэлцээний

Үеэр судлаж үзэхээр хоёр Тал тохиролцов.

#### IV

БНМАУ-ын хүсэлтийг харгалзан эдүүгээ хүртэл БНАГУ-аас олгосон зээл төлөх асуудлыг 1975 оны эцэс хүртэл хойшлуулахад БНАГУ бэлэн байна.

#### V

Хоёр орны хоорондын улс ардын аж ахуйн төлөвлөгөөний зохицуулалтаас үндэслэн хоёр Тал дараах зүйлийг тохиролцов:

-төлөвлөгөө зохицуулалтын үр дүнг БНМАУ,БНАГУ-ын Засгийн газар хоорондын комиссын хүрээнд гадаад эдийн засаг, худалдаа болон хоёр орны яамдын харилцан ашигтай хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд үндэс болгох;

- 2,3-р хавсралтанд заасан харилцан нийлүүлэх барааг 1971-1975 оны удаан хугацааны хэлэлцээрт оруулах;

- хоёр орны гадаад худалдааны байгууллагуудыг 1971 оны ба удаан хугацааны хэлэлцээрийн протоколыг боловсруулж ойрын хугацаанд гарын үсэг зурахыг хоёр орны гадаад худалдааны байгууллагад зөвлөх;

Хэлэлцээ хоёр орны хоорондын ах дүүгийн хамтын ажиллагаа найрамдалт байдалд боллоо.

Энэхүү протокол нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Протоколыг 1970 оны 12-р сарын 8-нд Улаанбаатар хотноо Монгол,немц,орос хэл дээр хоёр эх хувь үйлдэж гарын үсэг зурсан бөгөөд хоёр эх хувь ижил хүчин төгөлдөр болно.

Утгыг тайлбарлах талаар зөрөө гарвал орос эхийг үндэс болгоно.

Энэхүү Протоколын 1,2,3-р хавсралт түүний салшгүй хэсэг мөн.

БНМАУ-ЫН САЙД НАРЫН  
ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА

Д.ГОМБОЖАВ

БНАГУ-ЫН САЙД НАРЫН  
ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА

В.ТИТЕЛЬ

**ХЭЛЭЛЦЭЭРТ ОРОЛЦОГСОДЫН НЭРСИЙН  
Х А Г С А А Л Т**

**I. БНМАУ-ын төлөөлөгчдийн гишүүд**

- Д.Гомбожав - БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга
- Б.Ринчинпэлжээ - БНМАУ-ын Улсын Төлөвлөгөөний Комиссын дарга
- Е.Очир - Гадаад Худалдааны Яамны сайд
- Г.Дамдин - Гадаадтай эдийн засгийн талаар харилцах улсын хорооны орлогч дарга
- Ж.Дулмаа - Хөнгөн, хүнсний үйлдвэрийн яамны I-р орлогч сайд
- О.Нямаа - Хөдөө аж ахуйн яамны I-р орлогч сайд
- Б.Долгормаа - Сангийн яамны I-р орлогч сайд
- Х.Дамба - Түлш-эрчим хүчний үйлдвэр, геологийн яамны орлогч сайд

**Э к с п е р т ү ү д :**

- Б.Доржсүрэн - Улсын Төлөвлөгөөний Комиссын гадаад хэлтсийн дарга
- Х.Ядам - Гадаадтай эдийн засгийн талаар харилцах улсын хорооны хэлтсийн дарга
- Д.Юура - Гадаадтай эдийн засгийн талаар харилцах улсын хорооны ажилтан
- Д.Надмид - Гадаад худалдааны яамны худалдааны **танхимын** дарга
- Д.Сэд-Очир - Улаанбаатарын махкомбинатын асуудал хариуцсан Засгийн газрын төлөөлөгч
- Ц.Батхорлоо - Гадаад явдлын яамны ажилтан
- Д.Цэдэндамбаа - Түлш-эрчим хүчний үйлдвэр, геологийн яамны ажилтан

- И.Должинсүрэн - Улсын Төлөвлөгөөний Комиссын ажилтан  
Б.Адъяа - Улсын Төлөвлөгөөний Комиссын ажилтан  
Д.Одончимэг - Улсын Төлөвлөгөөний Комиссын ажилтан  
Г.Юндэн - Хөнгөн, хүнсний үйлдвэрийн яамны хэлтсийн дарга  
С.Дашням - Хөдөө аж ахуйн яамны хэлтсийн дарга

П.БНАГУ-ын төлөөлөгчдийн гишүүд

- Д-р В.Титель - БНАГУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга  
Д-р Х.Лайкауф - Орлогч сайд, Улсын Төлөвлөгөөний Комиссын олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга  
Д-р Г.Граф - Уул уурхай, төмөрлөг болон калийн үйлдвэрийн яамны орлогч сайд  
К.Энкельманн - Гадаадтай эдийн засгийн талаар харилцах яамны орлогч сайд  
Д-р В.Мостертиц - Монгол-Германы Засгийн газар хоорондын комиссын германы хэсгийн нарийн бичгийн дарга  
К.Студински - Гадаадтай эдийн засгийн талаар харилцах яам, засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч  
К.Рюлеманн - Сайд нарын Зөвлөлийн орлогч даргын нарийн бичгийн дарга нарын газрын эрхлэгч

Хэлэлцээрт оролцогчид

- Э.Роммель - БНАГУ-аас БНМАУ-д суугаа Элчин сайдыг түр хамаарагч  
К.Фридель - БНАГУ-аас БНМАУ-д суугаа Элчин сайдын яамны Зөвлөх  
В.Отто - БНАГУ-аас БНМАУ-д суугаа Элчин сайдын яамны худалдааны зөвлөх

Э к с п е р т у у д

- |                |                                                                                       |
|----------------|---------------------------------------------------------------------------------------|
| П.Темпельхаген | - Гадаадтай эдийн засгийн талаар харилцах яамны худалдааны зөвлөх                     |
| Л.Раам         | - БНАГУ-аас БНМАУ-д суугаа Элчин сайдын яамны худалдааны атташе                       |
| Х.Дёлер        | - Улаанбаатар хотын махкомбинатын барилгын германы талын дарга                        |
| А.Вайхерт      | - Улаанбаатар хотын хивсний үйлдвэрийн барилгын германы талын дарга                   |
| Е.Скрок        | - "Хольц унд папир" хэмээх гадаад худалдааны байгууллагын ажилтан                     |
| Х.Кёлер        | - Уул уурхай, төмөрлөг болон калийн үйлдвэрийн яамны группийн эрхлэгч                 |
| Ё.Мауер        | - Геологийн Төрийн нарийн бичгийн дарга нарын газрын ажилтан                          |
| Х.Беккер       | - Уул уурхай төмөрлөг болон калийн үйлдвэрийн яамны ажилтан                           |
| Э.Хаге         | - БНМАУ дахь БНАГУ-ын геологийн экспедицийн дарга                                     |
| А.Франк        | - Уул уурхай, төмөрлөг болон калийн үйлдвэрийн яамны ажилтан                          |
| З.Юнгманн      | - БНАГУ-аас БНМАУ-д суугаа Элчин сайдын яамны эдийн засаг-улс төрийн хэлтсийн ажилтан |
| Э.Дресслер     | - Улсын Төлөвлөгөөний Комиссын орчуулагч                                              |
| А.Хайден       | - Улсын Төлөвлөгөөний Комиссын нарийн бичгийн дарга нарын газрын ажилтан              |
| Х.Рудат        | - Гадаадтай эдийн засгийн талаар харилцах яамны нарийн бичгийн дарга                  |



2-р Хавсралт

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСААС БҮГД  
НАЙРАМДАХ АРДЧИЛСАН ГЕРМАН УЛСАД  
1971-1975 ОНД НИЙЛҮҮЛЭХ БАРААНЫ  
Ж А Г С А А Л Т

|                                            | : Хэмжих<br>: нэгж | : Тоо ба<br>: үнэ |
|--------------------------------------------|--------------------|-------------------|
| I.Мах,махан бүтээгдэхүүн                   | мян.тонн           | 17                |
| 2.Өлөн гэдэс                               | мян.горц           | 1000              |
| 3.Ноос ба хялгас                           | тонн               | 4600              |
| 4.Савхин дээл ба арьс ширэн жижиг<br>эдлэл | мян.руб.           | 3000              |
| Үүнээс: Савхин дээл                        | мян.шир.           | 46                |
| 5.Хивс                                     | мян.м <sup>2</sup> | 400               |
| 6.Тарваганы арьс                           | мян.шир.           | 300               |
| 7.Гянт болд 60 %                           | тонн               | 165               |
| 8.Мах ясны гурил                           | тонн               | 4000              |
| 9.Техникийн гранат                         | тонн               | 300               |
| 10.Гялтгануур                              | тонн               | 250               |
| II.Бусад бараа                             | мян.руб.           | 250               |

## БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН ГЕРМАН УЛСААС

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСАД

## 1971-1975 ОНД НИЙЛҮҮЛЭХ БАРААНЫ

## Ж А Г С А А Л Т

|                                                                   | :Хэмжих<br>:нэгж   | : Тоо ба<br>: үнэ |
|-------------------------------------------------------------------|--------------------|-------------------|
| 1.Махкомбинат,консервийн заводын<br>тоног төхөөрөмж,түүний сэлбэг | мян.руб.           | 2000              |
| 2.Хивсний үйлдвэрийн тоног төхөөрөмж,<br>түүний сэлбэг            | "                  | 1000              |
| 3.Хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж<br>ба материал,түүний сэлбэг  | "                  | 400               |
| 4.Гурван хлорт этилен                                             | тонн               | 1300              |
| 5.Хэвлэлийн будаг                                                 | мян.руб.           | 150               |
| 6.Техникийн ба кино хальс                                         | "                  | 650               |
| 7.Соронзон хальс                                                  | мян.м              | 650               |
| 8.Гүн хэвлэлийн цаас                                              | тонн               | 1000              |
| 9.Ном хавтаслах материал                                          | мян.руб            | 100               |
| 10.Химийн бараа                                                   | "                  | 200               |
| 11.Хагас ноосон бараа                                             | мян.м              | 1000              |
| 12.Хулдаас                                                        | мян.м <sup>2</sup> | 500               |
| 13.Сүлжмэл эдлэл                                                  | мян.руб.           | 1860              |
| 14.Бичгийн цаас                                                   | тонн               | 250               |
| 15.Бичгийн ба тооны машин,түүний<br>сэлбэг                        | мян.руб.           | 550               |
| 16.Эмийн зүйл                                                     | "                  | 375               |
| 17.Бусад бараа                                                    | "                  | 15000             |